

Захиргааны зөвлөлийн 2015 оны нэгдүгээр сарын 20-ны өдрийн шийдвэр

1. МУИС-ийн Бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журмын төслийг 2015 он тавиад оруулж ирсэн энэ хувилбараар нь батлах.
Сургалтын байгууллага орой, эчнээ сургалтын талаар боловсролын суралцаж байгаа хэлбэрээсээ хамаарч олгож байгаа боловсролын баримт бичиг нь өөр тайлбартай, ижил зөвшөөрөлтэй байх нь хэр зохимжтой вэ гэдэг талаас ХЗС-иас тайлбар авах.

Цаашид анхаарах зүйл:

- Элсэлтээс гадна сургалт нь ямар хэлбэрээр явах вэ? Бүртгэл хяналтын систем нь манай сиси системтэй яаж уялдаж, ойлгомжтой, тодорхой байх вэ?
 - Эчнээ сургалтыг цаашид цахим сургалтын ашигласан байхаар зохион байгуулалтыг тооцох,
 - Хөтөлбөрүүдээ албажуулах хэрэгтэй. Өдөр, орой, эчнээ тус бүрд нь зориулсан, онцлогт нь тохирсон хичээлийн төлөвлөлт, хичээлийн хөтөлбөр, зохион байгуулалтын ялгааг харуулсан баримт бичгүүд боловсруулах.
 - Эдийн засгийн үр ашиг наад зах нь алдагдалгүй байх. Ялангуяа ажлын бус цагаар, амралтын өдөр хичээл зааж байгаа хүмүүсийн цалин хөлснийг тооцож сургалтын төлбөртөө тусгах, гарч байгаа зардлыг хааж байхаар зардлын тооцоог хийх.
 - Цаашид энэ хөтөлбөрийг санал болгож байгаа, орой эчнээ сургалтыг цаашид үргэжлүүлэхээр төлөвлөж байгаа хөтөлбөрийн хороо, тэнхим, сургуулиуд дээрх асуудлыг тусгаж дараагийн журмын төслийг боловсруулахад оролцох. СНА ерөнхийд нь зохион байгуулах.
 - Авах шалгалтынхаа тухай зарлал өгөхдөө ойлгомжтой өгөх.
2. МУИС-ийн Оюутны холбоо, Оюутны конгресстэй байгуулах гэрээний төслийг хэлэлцээд дараах шийдвэрийг гаргалаа. Үүнд,
 - МУИС-ийн Оюутны холбоо, Оюутны конгресстэй байгуулсан гэрээг бүрэн эхээр нь веб сайтад байршуулж, нийт оюутны хяналтанд байлгах.
 - Оюутны байгууллагад шилжүүлж байгаа мөнгө шилэн дансны хуулийн дагуу ил харагдана.

- МУИС-ийн оюутны холбоо гэсэн байгууллагын статусыг ямар байлгах ёстой, энэ байгууллагын харьцааны талаар эрх зүйн хувьд мэргэжлийн тайлбар, зөвлөмжийг ХЗС-иас гаргаж өгөх.
 - МУИС-ийн Дүрмэнд тодруулсан тайлбар хийх /оюутны байгууллага нь ямар байгууллага байх вэ, яаж бүрдэх вэ, УЗ-д төлөөллөө оруулахдаа яаж, ямар шийдвэрээр оруулах гэх мэт/
 - Гэрээг нэг хичээлийн жилийн хугацаатай хийх
 - Гэрээ дуусахаас өмнө ХЗС-ийн гаргасан тайлбар, дүгнэлтийг Удирдах зөвлөлд оруулж, МУИС-ийн дүрмэнд оюутны байгууллагын талаар тодруулга оруулах.
3. ХШУИС, ШУС-ийн БУС-ын Сургалтын инженер, лаборантын Ажлын байрны тодорхойлолтыг авч хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав. Үүнд,
- ХШУИС /Ш.Нямбаа/ компьютерийн лабораторууд болон тэнд ордог хичээлийн хуваарилалт, ачаалал, байршлынхаа талаар СНА-наас нэгдсэн дүгнэлт гаргуулаад, ачааллыг жигдлээд, оюутны явах очих замыг багасгасан байдлаар байршлыг тогтоож, шийдлээ танилцуулах
 - АБТодорхойлолтыг нийтлэг байдлаар батлах
 - АБТ-нд сургууль бүр дээр зориулалт, ашиглалт, хаана харъяалагдах зэргээс хамаарч тодотгол хийх
 - Цаашид лабораториудад ашиглалт, зориулалтаасаа хамаараад сургалтын инженер байхуу, лаборант байх уу эсвэл мэдээллийн технологийн ажилтан байх уу гэдгийг дахин хэлэлцэж шийдвэрлэх
4. МТА-ны өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав. Үүнд,
- Сургалтын албаны ажилтнууд болон багш нарыг компьютертоо гарсан жижиг засвар, үйлчилгээг хэрхэн хийх талаар сургалтанд хамруулах хэрэгтэй юм байна. SiSi-тэй ажиллах зааврыг хэвлэж өгөх.
 - Нягтлан бодогч нарыг sisi-г хардаг болгох
 - Нямаа захирал үнэмлэхний машины техникийн тодорхойлолт, үзүүлэлтийг шалгаад, тодорхойлолтын дагуу нийлүүлсэн эсэхийг шалгах.
 - Бүртгэлийн системийг Багш сонгон шалгаруулалтын хувьд бүртгүүлсэн хүмүүс нэмэлт мэдээлэл оруулах болон төлбөрөө төлөхөд нь 2015 оны 01-р сарын 21-ний 12 цаг хүртэл нээх
 - Магистр, докторын элсэлтийн хувьд өнөөдрийн /2015.01.20/ 18 цаг хүртэл нээлттэй байлгах мөн төлбөрөө банкинд тушаан баримтаа авчирч шалгалтанд орж болно гэсэн зар тавих.

- МТА-ны ажилтныг тогтвортой ажиллах тал дээр Нямаа захирал санал боловсруулах.
- Мэдээллийн технологийн албатай холбоотой асуудлыг дахин хэлэлцэх. /хөрөнгө оруулалт, техникийн асуудал, хөгжүүлэлт, санхүүгийн программ/
- Амарзаяа багшийн LMS-г салгах гэсэн саналыг ярилцах хэрэгтэй.
- Багш нарын дүн оруулахад СНА-аас чиглэл өгөх. Дүн оруулахад сиси-г өнөөдрийн 18 цаг хүртэл нээх.

5. Бусад асуудал

- Багшийн сонгон шалгаруулалтын багшийн мэргэжлийн шалгалтыг 2015 оны 01 дүгээр сарын 21-нээс 27-ны хооронд авч, шалгалтын дүн, захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг 2015 оны 01 дүгээр сарын 28-нд ЗХШҮА-нд ирүүлэх
- 2015 оны 01 дүгээр сарын 29-нд англи хэлний шалгалт авахаар төлөвлөсөн байна.
- Бүрэлдэхүүн сургуулиуд үндсэн багшийн зэрэглэлд ажиллуулах дадлагажигч багшийн материалыг захиргааны зөвлөлийн шийдвэрийн хамт 2015 оны 01 сарын 21-нд ЗХШҮА-нд ирүүлэх